



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/553

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2. Б заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“БГМ” ХХК-ний орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сумын Цамбагарав багт ундны усны хангамж сайжруулах ухаалаг худагны ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: С.Гантөмөр – Жаргалант сумын Засаг дарга

Гишүүд: М.Цоггэрдэнэ –Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Л. Отгонцагаан - Цамбагарав багийн Засаг дарга

Л.Дагийсүрэн –“БГМ” ХХК захирал

Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн Жаргалант сумын Цамбагарав багт ундны усны хангамж сайжруулах ухаалаг худагны ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

D/Zax-A/553-Da

02 02722